



**МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ**

---

**Нүхэн жорлон, угаадасны нүх  
Техникийн шаардлага**

**MNS 5924 : 2015**

**Албан хэвлэл**

**СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР  
УЛААНБААТАР ХОТ  
2015 он**

## MNS 5924 : 2015

### Өмнөх үг

Стандартчилал, хэмжилзүйн газар (цаашид СХЗГ гэх) нь Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үндэсний стандартын төсөл боловсруулах ажлыг Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1 : 2006, MNS 1-2 : 2006 стандартын дагуу төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

Тус газар нь үндэсний стандарт боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Техникийн хороодоор хэлэлцэн, дэмжигдсэн стандартын төсөл нь Стандартчиллын үндэсний зөвлөлөөр хэлэлцэн, тогтоолоор баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэ стандартыг 2015 оны Барилгын стандартчиллын хөтөлбөрт тусгасны дагуу Монгол улсын зөвлөх инженер Ө.Цэдэндамба, мэргэшсэн инженер Ц.Гантулга, Эрүүл мэнд, спортын яамны мэргэжилтэн Ш.Уранцэцэг нар боловсруулж, Барилгын хөгжлийн төвийн мэргэжилтэн Г.Мөнхбаатар, доктор, проф Н.Сайжаа, Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн дэвшлийн төвийн мэргэжилтэн Б.Шижиртуяа, НҮБ-ын Хүүхдийн сангийн ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн мэргэжилтэн, Н.Батнасан Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэгийн гишүүн, А.Энхжаргал, НМХГ-ын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Б.Золбоо нар хамтран боловсруулсан болно.

СХЗГ-ын стандартын ахлах шинжээч, Монгол Улсын зөвлөх инженер Т.Энхтуул Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1:2006, MNS 1-2:2006-ын дагуу хянав.

Энэхүү стандартыг 2015 оны ТХ22/Барилгын стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэн дэмжиж, Стандартчиллын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан.

Энэ стандарт нь өмнөх MNS 5924 : 2008 стандартыг хүчингүй болгож, орлоно.

### Стандартчилал, хэмжилзүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар 13343, Ш/Х - 48

Утас 263860, 266754 Факс (976-11) 458032

E-mail: [www.masm.gov.mn](http://www.masm.gov.mn)

[www.estandart.mn](http://www.estandart.mn)

[www.estandart.gov.mn](http://www.estandart.gov.mn)

### © СХЗГ, 2015

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)–д байна.

**Агуулга**

- 0 Танилцуулга
  - 1 Зорилго
  - 2 Хамрах ба хэрэглэх хүрээ
  - 3 Норматив ишлэл
  - 4 Нэр томъёо, тодорхойлолт
  - 5 Ангилал
  - 6 Ерөнхий шаардлага
  - 7 Эрүүл ахуйн шаардлага
  - 8 Хүрээлэн буй орчны шаардлага
  - 9 Галын аюулгүйн шаардлага
  - 10 Угсралтын үед тавигдах шаардлага
  - 11 Суурийн нүх суллах, ариутгах, дахин ашиглах
  - 12 Буулгах шаардлага
  - 13 Угаадасны нүх, түүнд тавигдах шаардлага
  - 14 Буулгах үед тавигдах шаардлага
- Нүхэн жорлон, угаадасны нүхний зураг
- Нүхэн жорлон /Нэвчилтгүй/
  - Нүхэн жорлон /Хагас нэвчилттэй/
  - Нүхэн жорлон /Өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан/
  - Нүхэн жорлон /Газар хагас суулгасан суурийн нүхтэй/
  - Нүхэн жорлон /Угаадасны нүхний хамт/
- А.Хавсралт
- 1 Бордоожуулах жорлон
  - 2 Бага хэмжээний усаар зайлуулах жорлон
  - 3 Хуурайшуулах жорлон
- Ашигласан материал

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 91.140.80

Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага	MNS 5924 : 2015
Pit latrine and sewage pit. Technical requirements	MNS 5924 : 2008-ын оронд

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандартыг 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

### 1 Зорилго

Стандартын зорилго нь хүн амын амьдрах аюулгүй орчин бүрдүүлэх, байгаль орчныг бохирдлоос хамгаалах, халдварт өвчин үүсэхээс урьдчилан сэргийлэхэд оршино.

### 2 Хамрах ба хэрэглэх хүрээ

**2.1.** Төвлөрсөн болон бие даасан ариутгах татуургын системд холбох боломжгүй айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын ахуйн хэрэгцээнд хэрэглэх зориулалттай нүхэн жорлон, угаадасны нүхний зураг төсөл зохиох, барьж ашиглах, хяналт тавихад энэхүү стандартыг мөрдөнө.

**2.2.** Энэхүү стандартаар төвлөрсөн инженерийн байгууламж, шугам сүлжээнд холбогдсон болон бие даасан ариутгах татуургын системтэй инженерийн хийцтэй барилга, байгууламжийн үйл ажиллагааг зохицуулахгүй болно.

**2.3.** Энэхүү стандартын Хавсралт А/ Мэдээлэл/-ийн дагуу үйлдвэрийн хийцтэй болон бусад төрлийн жорлонгийн ашиглалт, үйлчилгээг зохицуулна.

### 3 Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах норматив баримт бичиг, стандартаас ишлэл хийсэн бөгөөд тэдгээрт нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн албан ёсны эх материалыг ишлэл болгоно. Үүнд:

**3.1.** MNS3342:82 Байгаль орчны хамгаалал. Усан мандал. Газрын доорхи усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага.

**3.2.** MNS4996:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага.

**3.3.** MNS 4990:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага.

**3.4.** MNS 4931:2000 Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага.

**3.5.** MNS 6055:2009 Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага.

**3.6.** MNS 6279:2011 Ус хангамж, ариун цэврийн байгууламж. нэр томъёо, тодорхойлолт- тайлбар толь.

3.7. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гарын авлага 1992.

#### 4 Нэр томьёо, тодорхойлолт

**4.1. Нүхэн жорлон** - тав тухтай орчинд бие засах зориулалт бүхий хүчитгэсэн болон энгийн доторлогоотой, тооцоолсон эзлэхүүнтэй нүхэнд хүний өтгөн, шингэн ялгадсыг цуглуулах, хуримтлуулж зайлуулах шаардлага хангасан хийц бүхий байгууламж

**4.2. Угаадасны нүх**- хүчитгэсэн болон энгийн доторлогоотой, тооцоолсон эзлэхүүнтэй нүхэнд ахуйн хэрэглээнээс гарсан бохир угаадсыг хуримтлуулах, зайлуулах, шаардлага хангасан хийц бүхий байгууламж

**4.3. Хагас нэвчилттэй жорлон, угаадасны нүх** - Энгийн доторлогоотой, тооцоолсон эзлэхүүнтэй нүхэнд хүний өтгөн, шингэн ялгадас болон ахуйн хэрэглээнээс ялгарсан бохир угаадсыг цуглуулах, хуримтлуулж зайлуулан нэг удаа ашиглах шаардлага хангасан хийц бүхий байгууламж

**4.4. Нэвчилтгүй жорлон, угаадасны нүх** - Хүчитгэсэн доторлогоотой, тооцоолсон эзлэхүүнтэй нүхэнд хүний өтгөн шингэн ялгадас болон ахуйн хэрэглээнээс гарсан бохир угаадсыг цуглуулах, хуримтлуулж зайлуулан давтан ашиглах шаардлага хангасан хийц бүхий байгууламж

**4.5. Жорлонгийн бүхээг** - хүн бие засахад тохиромжтой хэмжээг хангасан, чанар, стандартын шаардлага хангасан материалаар хийсэн тоноглол бүхий хийц

**4.6. Агааржуулалтын хоолой** - жорлон, угаадасны нүхнээс бохир агаарыг өөрийнх нь урсгалаар гадагш зайлуулах малгайвч бүхий хоолой

**4.7. Хаяавч** - жорлон, угаадасны нүхний газрын доорх болон дээрх хэсгийн хийцүүдийг холбосон тэдгээрт ус, хог хаягдал орохоос хамгаалсан цементэн зуурмагаар хийсэн налуу хийц

**4.8. Угаадасны нүхний амсар** – газрын гадаргаас дээш нүхний амсар дээр байрласан нүх, тор бүхий тагтай хийц

**4.9. Угаадасны нүхний хүзүүвч таг** – суурийн нүхэнд бохир уснаас бусад зүйл орохоос хамгаалсан нээж, хаахад хялбар хаалт

#### 5. Ангилал

Нүхэн жорлон, угаадасны нүхийг дараах байдлаар ангилна. Үүнд:

5.1. Шингэн хаягдал хөрсөнд шүүрэх байдлаар нь:

5.1.1 Нэвчилтгүй суурийн нүхтэй

5.1.2 Нэвчилттэй суурийн нүхтэй

5.2. Суурийн нүхний байрлалаар нь:

5.1.1 Газарт бүрэн суулгасан суурийн нүхтэй

5.1.2 Газарт хагас суулгасан суурийн нүхтэй

5.3. Хэрэглэгчийн зориулалтаар нь:

5.3.1 Насанд хүрэгчдэд

5.3.2 Хүүхдэд

5.3.3 Хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настанд зориулсан бүхээгтэй гэж ангилна

## 6. Ерөнхий шаардлага

6.1. Нүхэн жорлон нь суурийн нүх, шал, бүхээг, хаяавч, агааржуулалтын хоолойн хэсгээс бүрдэнэ.

6.2 Суурийн нүх

6.2.1 Суурийн нүхний эзлэхүүнийг хэрэглэгчийн тооноос хамааруулан тооцно. Суурийн нүхний өндөрийг газрын хөрсний хөлдөлтийн түвшинтэй уялдуулж, хөрсний уснаас дээш 2м-ээс багагүй түвшинд ухна.

6.2.2 Дулааны улиралд угаадасны нүхэнд тунгаагдсан бохир ус жорлонгийн нүхэнд орж байхаар жорлон угаадасны нүхийг холбосон халих хоолой хийж болно.

6.2.3 Бүхээгийн ар талын хананаас хойшхи нүхний дунд хэсэгт бохирыг соруулах, ухаж цэвэрлэхэд зориулсан хүзүүвч бүхий зориулалтын тагтай байна.

6.2.4 Хүчитгэсэн доторлогоотой нүх нь ээлжлэн ашиглаж болох зэрэгцээ нүхтэй байж болно.

6.2.5 Суурийн нүх нь хөрсний усны түвшин өндөр, намагтай, нурамтгай хөрстэй газарт зайлшгүй магниум хавтан зэрэг хүчитгэсэн доторлогоотой байна.

6.2.6 Хад чулуутай хөрсөнд суурийн нүхийг хүзүүвч хэлбэрээр газрын гадаргуугаас дээш өндөрлөж болно.

6.2.7 Суурийн нүхэн дэх ялгадсын хэмжээ нүхний амсраас доош 50 см хүрсэн тохиолдолд энгийн доторлогоотой бол булна, хүчитгэсэн доторлогоотой бол бохирыг соруулж зайлуулна

6.2.8 Суурийн нүхний эзэлхүүнийг ашиглах хүний тоо, ашиглахаар төлөвлөсөн жил, суурь коэффициент 0.06 м<sup>3</sup>-ээр үржвэрээр тооцоолно.

6.2.9 Суурийн нүхэнд ариун цэврийн хэрэглэл, хог хаягдал хийхийг хориглоно.

6.3. Шал

6.3.1 Бүхээгийн шалыг суурийн нүхний амсар дээр ачаалал даах, бат бэх материалаар дамнуурга зориулалтаар хэрэглэнэ. Тэдгээрийг нүхний амсар дээр дамнуулан суулгахдаа хөрсний шинж чанарыг харгалзах бөгөөд уртын дагуу нүхний доторлоогүй амсраас 150 мм, хөрсний түвшингээс 100 мм-ээс багагүй байхаар тус тус ухаж байрлуулна.

6.3.2 Бүхээг тавих дамнуургын хэсэг дээр 50 мм-ээс багагүй зузаан банз түүнтэй адилтгах материалаар зай завсаргүй шаллаж, жорлонгийн бүхээгийг байрлуулан сайн бэхэлж тогтоосон байна. Шалыг бетон хавтангаар хийж болно.

6.3.3 Жорлонгийн шалны дунд хэсэгт бие засах нүх гаргаж, суух гишгүүр байрлуулж бэхэлнэ. Өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан жорлонд суурин болон зөөврийн суултуур суурилуулж болно.

6.3.4 Насанд хүрэгчдийн жорлонгийн шалны бие засах нүхний урт 380 мм, өргөн нь 250 мм байхаар тооцож, зууван хэлбэрийн нүх гаргах бөгөөд бүхээгийн ар хана

## MNS 5924 : 2015

талаас нүхний ирмэг хүртэл 180 мм-ээс багагүй зайтай байна. Хүүхдийн жорлонгийн бие засах нүхний урт 280 мм, өргөн 180 мм-ээс ихгүй байна.

6.3.5 Бүхээгийн шалыг будах буюу хальтиргаа, гулгаанаас хамгаалсан зориулалтын материалан өнгөлсөн байна.

### 6.4. Бүхээг

6.4.1 Бүхээгийн хана, дээвэр, тэдгээрийн уулзвар зай завсаргүй, хаалга нь бүрэн онгойж хаагдаж байхаар, цэвэр, өнгө үзэмжтэй байна.

Бүхээгийг амархан сөхөгддөг, буулгахад хялбархан, хөнгөн, бөх бат материалаар гүйцэтгэвэл зохино.

6.4.2 Бүхээгийн хаалга тал нь өндөр, ар тал нь нам, хажуу талууд нь ижил өндөртэй байна. Нийтийн жорлонгийн бүхээгийн ерөнхий урт нь суултуурын тооноос хамаарах бөгөөд суултуур бүр нь ханаар бүрэн тусгаарлагдсан байна.

6.4.3 Бүхээгийн хэмжээ нь 1-р хүснэгтэд заасан хэмжээтэй тохирсон байна.

1-р хүснэгт

Бүхээгийн ялгаа	Хэмжээ, мм		
	Нүүрэн талын өндөр	Ар талын өндөр	Хажуу талын өргөн
Том хүний жорлон	2400	2100	1200
Хүүхдийн жорлон	1600	1400	900
Хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настны жорлон	2400	2100	1800

ТАЙЛБАР: Нийтийн жорлонгийн урт нь талын уртыг суудлын тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.

6.4.4 Жорлонгийн бүхээгийн хаалгыг нарны гэрлийн тусгалын эсрэг тал руу харуулж байрлуулах бөгөөд хаалганы дээд талд 400 мм урт, 200 мм өргөн цонхтой байна.

6.4.5 Бүхээгийн хаалга гадна, дотор талдаа түгжээтэй байх бөгөөд шөнийн цагт гэрэлтүүлэгтэй, бүхээгний хаалганы дээр ялаа, шавьж орохоос хамгаалсан тор бүхий цонхтой байна.

6.4.6 Бүхээг дотор ариун цэврийн цаас, өлгүүр, тагтай хогийн сав, цэвэрлэгээний тоноглол, хэрэгсэл байрлуулсан байна.

6.4.7. Бүхээгийн материал сонголтоос хамааруулан сууринд ирэх ачааллыг тооцсон байвал зохино.

### 6.5. Хаяавч

6.5.1 Жорлонд цас, борооны ус орох, ялааны авгалдай хөрсөөр нэвтэрч гарахаас хамгаалан жорлонгийн бүхээгний эргэн тойронд 500 мм-ийн зайнд бетон зуурмаг, чулуу, тоосго, хайрга зэрэг материалаар жорлонгийн суурийг нүхний амсартай зай

завсаргүй холбосон 100 мм-ийн зузаан, жорлонгийн хананаас гадагш налуу бүхий хаяавч хийнэ.

#### 6.6. Агааржуулалтын хоолой

6.6.1 Жорлон бүр агааржуулалтын хоолойтой байх ба уг хоолой нь бүхээгийн ар талын ханын дунд хэсэгт нүхний харалдаа байрлуулсан байна. Салхивчийн хоолойн өндөр бүхээгний арын хананы өндрөөс 200 мм- ээс багагүй өндөр, голч нь 200 мм буюу дөрвөлжин бол 200 мм х 200мм хэмжээтэй хийж, түүний дээд үзүүрт малгайвч, ялааны тороор тоногдсон байвал зохино.

6.7 Өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан жорлон дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

6.7.1 Тэргэнцэртэй хүн багтахуйц зайтай буюу бүхээгний өргөн, уртын хэмжээ 1.65 м х 1.8 м-ээс багагүй, суурин болон зөөврийн суултуур байрлуулах ба түүний хажуу хэсэгт тэргэнцэр байршуулах чөлөөтэй орон зайтай байна.

6.7.2 Хаалганы өргөн нь 1.0 м-ээс багагүй байх ба зориулалтын бариултай байна.

6.7.3 Тэргэнцэртэй хүнд шаардлагатай үед тусламж дуудах хонх, чимээ гаргах тоноглолтой байна.

6.7.4 Тэргэнцэртэй ижил өндөртэй, зөөлөвч бүхий суултуур, хамгаалалтын бүстэй байна.

6.7.5 Тэргэнцэрээс суултуурт шилжин суухад туслах, сууж байхад гар, мөр, нурууг дэмнэх тулгуур суурилуулж тогтоосон байвал зохино.

6.7.6 Хаалга нь босгогүй, довжооны налуу нь стандартын шаардлага хангасан байна.

6.7.7 Жорлонгийн босгоноос гэрийн хаалга хүртэл тэргэнцэрээр явж болохуйц налуу довжоо, замтай байна

6.8. Жорлон, угаадасны нүхийг байрлуулахдаа орон сууц, гэрийн байрлал, салхины урсгалын чиглэл, усны эх булаг зэрэг хүчин зүйлийг харгалзан үзэж байршилыг сонгоно.

6.9. Хот, суурин газар жорлонгийн гадна, дотор талд гэрэлтүүлэг, гэр, орон сууцны хаалганаас жорлон хүртэлх зайд зам тавьж орчныг цардах, нягтруулах зэргээр тохижуулахаас гадна жорлонг доторлож зай завсаргүй битүүлсэн байна.

6.10. Жорлонгийн хаалга гадна, дотор талдаа түгжээтэй, угаадасны нүх тагтай байх бөгөөд хаалга, таглааг байнга хаалттай байлгана. Хаалга түгжигдсэн байгааг гаднаас мэдэх боломжтой түгжээтэй байвал зохино.

6.11. Ус түгээх цэг, голын эргийн ойролцоо байрлах жорлон, угаадасны нүхний хана, ёроолыг барилгын норм ба дүрэм, инженерийн бат бөхийн тооцоо шаардлагыг хангасан ус, чийг тусгаарлах материалаар доторлон тохижуулж хийц, материалын чанарын үзүүлэлтийг тухайн сум, баг, хорооны тухайн асуудал хариуцсан ажилтанд тэмдэглүүлнэ.

6.12. Нийтийн зориулалттай жорлонд тавигдах нийтлэг шаардлага

6.12.1 Нийтийн нүхэн жорлонд эмэгтэй, эрэгтэй тусдаа, бүхээгний тооны харьцаа 3:1 байна.



## **MNS 5924 : 2015**

6.12.2 Нийтийн нүхэн жорлонд хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдэд зориулсан 1-ээс багагүй бүхээгтэй байна.

6.12.3 Хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчид зориулсан гар угаагууртай байна.

6.12.4 Эрэгтэй өрөөнд шээлтүүр байрлуулж болно.

### **7. Эрүүл ахуйн шаардлага**

7.1. Жорлонгийн бүхээгийг ариутгаж цэвэрлэх боломжтой, ус чийгэнд тэсвэртэй, өвчин үүсгэх мөөгөнцөр, нян бактери, хортон шавьж үржихгүй, гэрлийн тусгалаас хамгаалагдсан материалаар доторлосон байвал зохино.

7.2. Жорлонгийн бүхээг дотор ариутгал цэвэрлэгээний зөвшөөрөгдсөн бодис ба хэрэгслэлүүдийг бага насны хүүхдийн гар хүрэхээргүй газарт байрлуулан тавьсан байна.

7.3. Жорлон, угаадасны нүхний орчинд ялаа шавьж үржих, орогнох боломжийг таслах зорилгоор дулааны улиралд ариутгал, халдваргүйжүүлэлтэд шинэ технологи, био бэлдмэлийг зохих стандартын дагуу устгал, ариутгал хийнэ.

7.4. Нүхэн жорлон, угаадасны нүхийг гэр, сууцнаас аль болох хол зайд, орон сууц, нийтийн байр, үйлчилгээний газраас 15 метр, ус түгээх цэгийн байрнаас 20 метр, уурхайн болон өрөмдмөл худгаас 150 -аас 250 метр, голын эргээс 200-250 метрээс багагүй зайд, татмын гадна ноёлох салхины доод талд барьж ашиглана.

7.5. Бие засах нүх зориулалтын тагтай байх бөгөөд хэт халуун болон шөнийн цагаар таглаж, салхитай өдөр онгорхой байлгавал зохино.

7.6. Жорлон, угаадасны нүхний орчинд ялаа шавьж үржих, орогнох боломжийг таслах зорилгоор дулааны улиралд стандартын шаардлага хангасан зориулалтын бодис хэрэглэн 7 хоног тутамд устгал хийж байна.

### **8. Хүрээлэн буй орчны шаардлага**

8.1. Нүхэн жорлон, угаадасны нүх ашиглагч, эзэмшигч нь тэдгээрийн ашиглалтын явцад ил задгай болон газрын доорх усны эх үүсвэр, хөрс агаарыг бохирдуулахгүй байх, хүн амыг эрүүл аюулгүй орчинд амьдрах байгаль орчинг хамгаалах нөхцөлийг хангахаар төлөвлөж, байгуулж ашиглана.

8.2. Угаадасны нүх, жорлонг аль болох нэг дор ойролцоо байхаар тооцоолон байрлуулна.

8.3. Нүхэн жорлон, угаадасны нүхийг нийтийн эзэмшлийн газар, үерийн ус буудаг газарт барьж байгуулахыг хориглоно.

8.4. Нүхэн жорлон, угаадасны нүхийг ноёлох салхины доод тал 2-р хүснэгтэд заасан хэмжээнээс багагүй зайд барьж байгуулахыг зөвшөөрнө.

## 2-р хүснэгт

<u>Гэр, амины орон сууц</u>	8 метр
<u>Орон сууц, нийтийн байр, үйлчилгээний газар</u>	20 метр
<u>Ус түгээх цэг, гүний худаг</u>	25 метр
<u>Усны эх үүсвэр, голын эрэг</u>	200 метр

**8.5.** Нүхэн жорлон, угаадасны нүх ашиглагч нь эдэлбэр газрынхаа орчны тохижилт, зүлэгжүүлэлт, ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалтыг байгаль орчныг хамгаалах хууль, дүрэм, норм стандартын дагуу гүйцэтгэсэн байна.

**8.6.** Жорлон, угаадасны нүхэнд элдэв хог, хаягдал цаас, хоолны үлдэгдэл хийхгүй, жорлонд хэрэглэсэн цаас, бусад хогийг тагтай саванд хийж цуглуулан, хог хаягдалтай хамт зайлуулна.

## 9. Галын аюулгүйн шаардлага

**9.1.** Жорлонгийн бүхээгний хийц, дулаалга, өнгөлгөө, доторлогоонд орох материалууд нь галд тэсвэртэй байх, эсвэл тухайн материалыг галд тэсвэртэй бодисын уусмалаар түрхлэг хийж шингээгдсэн байна.

**9.2.** “MNS 4244:1994 Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага” стандартын шаардлага хангасан байна.

## 10. Угсралтын үед тавигдах шаардлага

**10.1.** Жорлон, угаадасны нүхийг зохих шаардлагад нийцсэн зураг, төсвөөр барьж байгуулна.

**10.2.** Жорлон, угаадасны нүхний байршлын сонголтыг хэрэглэгчийн байрлал, салхины урсгалын чиглэл, усны эх булаг зэрэг хүчин зүйлийг харгалзан холбогдох норм, дүрэм, стандартад нийцүүлсэн байна.

**10.3.** Угаадасны нүх, жорлонг нэг дор ойролцоо байхаар тооцоолон байрлуулна.

**10.4.** Хот, суурин газар жорлонгийн гадна дотор талд гэрэлтүүлэг, гэр, сууцны хаалганаас жорлон хүртэлх зайд зам тавьж орчныг цардах, нягтруулах зэргээр тохижуулахаас гадна жорлонг доторлож зай завсаргүй битүүлсэн байна.

## 11. Суурийн нүхийг суллах, ариутгах, дахин ашиглах

**11.1.** Нэвчилтгүй суурийн нүхний эзлэхүүний 90 % нь ялгадас, хөлдүүсээр дүүрэх үед түүнийг соруулах буюу суллаж бохирыг холбогдох журмын дагуу зайлуулж, ариутгал хийж дахин ашиглана.

**11.2.** Жилд 2 удаа суурийн нүхийг суллах, бохирыг зайлуулах, ариутгах ажлыг гүйцэтгэвэл зохино.

## 12. Буулгах шаардлага

**12.1.** Дахин ашиглах боломжгүй жорлон, угаадасны нүхний бохирдсон хөрсийг зайлуулж халдваргүйжүүлэлт хийн эрүүл хөрсөөр дүүргэж ариутгана.

**13. Угаадасны нүх, түүнд тавигдах шаардлага**

13.1. Угаадасны нүхний эзлэхүүн хэмжээ нь ашиглах хүний тоо, усны хэрэглээ ашиглах хугацаа зэргээс хамаарах бөгөөд 3-р хүснэгтэд заасан хэмжээтэй тохирсон байна.

3-р хүснэгт

Угаадасны нүх	Дундаж хэмжээ, мм		
	урт	өргөн	гүн
	3000	2500	3000

ТАЙЛБАР: Нэг хүнээс жилд 3600 л буюу 3.6 м3 бохир ус гарахаар тооцож үзвэл 4-5 ам бүлтэй нэг айлд 14.4 – 18 м3 багтаамжтай нүх ухвал жилийн турш ашиглахад хүрэлцээтэй гэж жишгээр тооцно.

13.2. Угаадасны нүхний ханыг бетон, тоосго, магниум хавтан, чулуу зэрэг ус чийгнээс хамгаалах стандартын шаардлага хангасан тусгаарлагч материалаар доторлож ёроолын хөрс хэвээр үлдээж тэгшилээд 100-аас 150 мм зузаан ул хийнэ. Шаардлагатай гэж үзвэл бохир ус хөрсөнд нэвчихээс найдвартай хамгаалсан бетон хашлага, доторлогоо хийнэ.

13.3. Нүхний амсар дээр мод, төмөр, төмөр бетон, магнум хавтан зэргийг дамнуулан тавьж зай завсаргүй, цөмөрч доошоо унахааргүй таглаа хийж, нүүрсний үнс, модны үртэс зэргээр дулаалж шороогоор бага зэрэг өндөрлөж хучилт хийнэ.

13.4. Угаадасны нүхний таглааны дунд хэсэгт түүний талбайн дөрөвний нэгтэй тэнцэх хэмжээний бохир ус соруулах, ухаж лайдах зориулалтын таг байрлуулж , агааржуулалтын 0.5 - 1.0 м өндөр яндан хоолой гаргаж өгнө.

13.5. Угаадасны нүхний хучилтыг хүзүүвчээс гадагш бага зэрэг налуу хийж, налуулсан ирмэгийг шавардах буюу чулуу, шавраар өнгөлнө.

**14. Буулгах үед тавигдах шаардлага**

14.1. Нэвчилттэй жорлон, угаадасны нүхний эзлэхүүний 90 хувь нь ялгадас, хөлдүүсээр дүүрэх үед жорлонгийн бүхээгийг зайлуулан нүхийг 30 см-ээс багагүй зузаан шороогоор булна. Ялгадас доош шингэж хөрс суулт өгөх бүрт шороогоор нэмж булна.

14.2. Жорлон, угаадасны нүхэн доторх ялгадас, угаадасыг соруулж халдваргүйжүүлэлт хийсний дараа эрүүл хөрсөөр дүүргэж булна. Ялгадас, угаадасыг зөвшөөрөгдсөн цэгт зохих журмын дагуу зөөж зайлуулна.


14.3 Жорлон, угаадасны нүх байсан суурин дээр мод, зүлэг тарьж хөрсийг нөхөн сэргээнэ.

ТАЙЛБАР: Байгууллага иргэдээс бололцоогоо ашиглан энэхүү стандартад заасан ерөнхий шаардлага, зураг дээр үзүүлсэн загваруудад нийцүүлэн дэвшилтэт жорлон, угаадасны нүх барьж ашиглахыг зөвшөөрнө.

**НҮХЭН ЖОРЛОН / Нэвчилтгүй /**


**Байгуулалт М 1:50**

**Дээврийн байгуулалт М 1:50**




НҮХЭН ЖОРЛОН / Хагас нэвчилттэй /


Байгуулалт М 1:50




Дээврийн байгуулалт М 1:50




Огтлол 1-1 М 1:50



Нүүр тал М 1:50




Хажуу тал М 1:50



**НҮХЭН ЖОРЛОН / Угаадасны нүүний хамт /**

**УГААДСНЫ НҮХ / Салангид**



**А.Хавсралт**

**/Мэдээллийн/**

**Зөөврийн болон үйлдвэрийн хийц бүхий “Био жорлон”, “Бага хэмжээний усаар зайлуулах жорлон”, “Хуурайшуулах жорлон” зэрэг байгууламжийн ашиглалт, үйлчилгээ**

**Агуулга**

Нэг. Бордоожуулах жорлон (Composting toilet)

- 1.1. Танилцуулга
- 1.2. Хийц бүтээц
- 1.3. Байршил
- 1.4. Хэрэглээ, үйлчилгээ
- 1.5. Суллах, зайлуулах

Хоёр. Бага хэмжээний усаар зайлуулах жорлон (Pour flush toilet)

- 2.1. Танилцуулга
- 2.2. Хийц бүтээц
- 2.3. Байршил
- 2.4. Хэрэглээ, үйлчилгээ
- 2.5. Суллах, зайлуулах

Гурав. Хуурайшуулах жорлон (Dehydrating toilet)

- 3.1. Танилцуулга
- 3.2. Хийц бүтээц
- 3.3. Байршил
- 3.4. Хэрэглээ, үйлчилгээ
- 3.5. Суллах, зайлуулах

Дөрөв. Ашигласан материал

## Нэг. Бордоожуулах жорлон (Composting toilet)

### 1.1 Танилцуулга

Бордоожуулах жорлон нь ялгагдсыг тусгаарлах зориулалтай бөгөөд шингэн нь нүүхэнд шингэж, өтгөн нь саванд хураагдана. Өтгөн хураах сав дүүрсэний дараа суллах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан эрх бүхий байгууллагад хандаж өтгөнийг зайлуулна. Цуглуулсан өтгөнөөс үйлдвэрлэлийн орчинд бордоо гаргаж авна. Ингэж өтгөнийг бордоо болгодоогоороо энэ төрлийн жорлон байгаль орчинд ээлтэй, үр ашигтай технологи юм.

### 1.2. Хийц бүтээцийн онцлог

Био жорлон нь нүх, суурь, бүхээг гэсэн үндсэн хийцтэй. Өтгөн шингэнийг тусгаарлах суултуур, өтгөн хураах сав гэсэн нэмэлт тоноглолтой.

Нүх: Шингэнийг газарт нэвчүүлэх, энгийн доторлогоотой нүх байна. Нүхний эзэлхүүн  $1\text{м}^3$  байна.


Суурь: Нүхний дээр суурь байрлана. Суурин дотор өтгөн хураах савыг байрлуулна. Суурийн өргөн бүхээгний өргөнтэй ижил, урт нь бүхээгний урт, агааржуулалтын хоолойн диаметрийн нийлбэртэй тэнцүү, өндөр нь 800мм байна. Өтгөн хураах савыг суллах зориулалтаар суурийн ар талд хаалга хийнэ. Хаалганы өргөн нь суурийн өргөний  $2/3$ -той тэнцүү байна.

Бүхээг: Стандартын шаардлага хангасан байна.

Өтгөн хураах сав: Суллах боломжтой дунджаар 100-150 литрийн багтаамжтай сав байна. Энэ нь 5 ам бүлтэй айл 3 сар хэрэглэхээр тооцсон жишиг хэмжээ юм.

Өтгөн шингэнийг тусгаарлах суултуур: Энэхүү суултуур нь 2 таславчтай байна. Бие засах үед шээс нь таславчийн урд талын хэсэгт холбогдсон хоолойгоор урсаж нүүхэнд шингэнэ. Өтгөн нь таславчийн арын хэсгээр дамжин өтгөн хураах саванд орно.

Агааржуулалт: Стандартын шаардлага хангасан байна.



1-р зураг - Бордоожуулах жорлон



Эх үүсвэр: “UNDP 2013, Төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжийн хувилбарууд” (Зургийн цомог)

### 1.3. Байршил

- Жорлонг гэр, амины орон сууцны гадна эсвэл залгаа байхаар төлөвлөнө.

### 1.4. Хэрэглээ үйлчилгээ

- Бүхээгт үртэс, хар шороо зэрэг органик материалаар дүүргэсэн сав байрлуулна. Бие зассаны дараа ялгадсыг тухайн органик материалаар далдалж хучина.
- Жорлонгийн шалыг усаар тогтмол угааж, цэвэрлэнэ.
- Өтгөн хураах саванд угаадас, хог хаягдал, халдваргүйжүүлэгч бодис хийхийг хориглоно.
- Агааржуулалтын хоолойг хар өнгөөр будах ба энэ нь ялгадас хатах явцыг дэмжинэ.

### 1.5. Суллах, зайлуулах

Өтгөн хураах сав дүүрсэний дараа суллах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан эрх бүхий байгууллагад хандаж өтгөнийг зайлуулна.

### Хоёр. Бага хэмжээний усаар зайлуулах жорлон (Pour flush toilet)

#### 2.1 Танилцуулга


Бага хэмжээний усаар зайлуулах жорлон нь ялгадсыг усны урсгалаар нүх уруу хөөх зарчимд тулгуурлана. Суултуурын дор “S хэлбэрийн хаялга” бүхий ялгадас зайлуулах хоолойг суурьлуулснаар усаар зайлуулдаг жорлонтой харьцуулахад харьцангуй бага ус хэрэглэн үнэрийг дарах сайн талтай.

#### 2.2 Хийц бүтээц

Бага хэмжээний усаар зайлуулах жорлон нь нүх, бүхээг гэсэн үндсэн хийцтэй. Бүхээг нь нүхний дээр эсвэл нүхний хажууд байрлах 2 хувилбартай. Суултуурын дор “S хэлбэрийн хаялга” бүхий ялгадас зайлуулах хоолойтой.

Нүх: Суурийн нүх нь ус үл нэвчүүлэх хүчитгэсэн доторлогоотой байна. Нүхний эзлэхүүн нь уг жорлонг ашиглах хүний тоо, усны хэрэглээ, ашиглах хугацаанаас хамаарна.

Бүхээг: Стандартын шаардлага хангасан байна.



2-р зураг. Бага хэмжээний усаар зайлуулах жорлон

Эх үүсвэр: “UNDP 2013, Төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжийн хувилбарууд” (Зургийн цомог)

### 2.3 Байршил

- Жорлонг амины оронсууцны дотор эсвэл гадна байхаар төлөвлөнө.

### 2.4 Хэрэглээ, үйлчилгээ

- Ялгадсыг зайлуулахдаа зөөврийн устай тохиолдолд нэг удаад 2-3 литрээс багагүй, ус нөөцлөх савтай тохиолдолд 4 литрээс ихгүй хэмжээний ус хэрэглэнэ.
- Шалыг бага зэрэг налуу хийх ба энэ нь усны урсацыг сайжруулдаг.
- Бүхээг нь нүхний дээр байрлах хувилбарыг дулааны улиралд хэрэглэнэ.
- Бүхээг нь нүхний хажууд байрлах хувилбарыг хүйтний улиралд хэрэглэх тохиолдолд “S хэлбэрийн хаялга” болон ялгадас зайлуулах хоолойг дулаална.

### 2.5 Суллах зайлуулах

Суурийн нүхэн дэх ялгадсын хэмжээ нүхний амсраас доош 50 см хүрсэн тохиолдолд ялгадсыг соруулж, зориулалтын тээврийн болон техник хэрэгсэл ашиглан зөвшөөрөгдсөн цэгт зохих журмын дагуу зөөж зайлууна.

### Гурав. Хуурайшуулах жорлон (Dehydrating toilet)

#### 3.1 Танилцуулга

Хуурайшуулах жорлон нь ялгадсыг хатаах зарчимд тулгуурласан тул өтгөний жин, хэмжээ, эмгэг төрөгч бичил биетэнг үлэмж хэмжээгээр бууруулдаг. Энэ төрлийн жорлон нь хуурай уур амьсгалтай оронд хэрэглэхэд тохиромжтой.

#### 3.2 Хийц бүтээц

**Хуурайшуулах жорлон** нь нүх, суурь, бүхээг гэсэн үндсэн хийцтэй.

**Нүх:** Шингэнийг газарт нэвчүүлэх, энгийн доторлогоотой нүх байна. Нүхний эзэлхүүн  $1\text{м}^3$  байна.


**Суурь:** Нүхний дээр хоёр тасалгаатай суурь байрлана. Суурийн өргөн нь 2000мм, урт нь бүхээгний урт, агааржуулалтын хоолойн диаметрийн нийлбэртэй тэнцүү, өндөр нь 800мм байна.

## MNS 5924 : 2015


Суурийн ар тал налуу хийцтэй байна. Налуу хэсэгт ялгадсыг суллах зориулалтаар хаалга хийнэ. Хаалганы өргөн нь суурийн өргөний 2/3-той тэнцүү байна. Хаалгыг дулаан дамжуулах материалаар хийнэ. Энэ нь нарны гэрлийг илүү шингээж ялгадас хуурайшиж хатах нөхцлийг бүрдүүлнэ.

Бүхээг: Стандартын шаардлага хангасан байна. Бүхээг нь суурийн дунд хэсэгт байрлана. Бүхээгт суурь тус бүрийн харалдаа бие засах нүх гаргах эсвэл суултуур байрлуулна.

Агааржуулалт: Стандартын шаардлага хангасан байна.



Хажуугийн зүсэлттэй зураг



Урд талын зүсэлттэй зураг

### 3-р зураг. Хуурайшуулах жорлон

**Эх сурвалж:** “UNDP 2013, Төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжийн хувилбарууд” (Зургийн цомог)

### 3.3 Байршил

- Жорлонг гэр, амины орон сууцны гадна байхаар төлөвлөнө.

### 3.4 Хэрэглээ үйлчилгээ

- Суурийн хоёр тасалгааг ээлжлэн хэрэглэнэ. Хэрэглэж байгаа суурийн тасалгаа ялгадсаар дүүрэх үед бие засах нүхийг таглаж, нөгөө тасалгааг хэрэглэнэ.
- Жорлонгийн шалыг усаар тогтмол угааж, цэвэрлэнэ.
- Өтгөн хураах саванд угаадас, хог хаягдал, халдваргүйжүүлэгч бодис хийхийг хориглоно.
- Агааржуулалтын хоолойг хар өнгөөр будах ба энэ нь ялгадас хатах явцыг дэмжинэ.

### 3.5 Суллах зайлуулах

Хатаж хуурайшсан өтгөнийг хатуу хог хаягдалтай хамтэсвэл суллах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан эрх бүхий байгууллагад хандаж зайлуулна.

**Ашигласан материал**

1. БХБЯ, НҮБ-н ХХ, 2012, Бие даасан ариун цэврийн байгууламж, Улаанбаатар хот
2. СХЗГ, 2012, Ус хангамж, ариун цэврийн байгууламж. Нэр томъёо, тодорхойлолт-Тайлбар толь, MNS 6279:2011, Улаанбаатар
3. ДЭМБ 1992, Орон нутагт ариун цэврийн байгууламж барих зөвлөмж
4. Simon Farmer, 2012, Ventilated Improved Pit Latrine, Practical Action, Technical brief, The Schumacher Centre for Technology and Development, UK  
[https://www.engineeringforchange.org/static/content/Sanitation/S00040/vip\\_latrines.pdf](https://www.engineeringforchange.org/static/content/Sanitation/S00040/vip_latrines.pdf)
5. Brenda Land, 1995, Composting toilet systems, planning, design, & maintenance, Technology & Development Program (U.S.) San Dimas Technology & Development Center
6. WHO, 1992, Guide to the development of onsite sanitation,  
<http://helid.digicollection.org/en/d/Jh0210e/3.2.13.html#Jh0210e.3.2.13>
7. UNDP, WB, D. Duncan Mara, The Design of Pour-Flush Latrines, Interregional Project INT/81/047, Technology Advisory Group (TAG),  
[http://www.sswm.info/sites/default/files/reference\\_attachments/MARA%201985%20The%20Design%20of%20Pour%20Flush%20Latrines\\_0.pdf](http://www.sswm.info/sites/default/files/reference_attachments/MARA%201985%20The%20Design%20of%20Pour%20Flush%20Latrines_0.pdf)
8. Hanna Lindbom, 2006, Designing local sanitation facilities for Mongolia, Lunea University of Technology, master thesis.



**MONGOLIAN STANDARD**

---

**Pit latrine and sewage pit  
Technical requirements**

**MNS 5924: 2015**

**Official publishing**

**MONGOLIAN NATIONAL CENTER FOR STANDARDIZATION AND METROLOGY  
ULAANBAATAR  
2015**

## Preface

